

**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****2025 оны 5 сарын 14 өдөр****Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага****1.1. Хууль зүйн шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван ес штрих 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг “Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан нь намын үйл ажиллагаа нь нийтэд ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлэх цаашлаад намын үйл ажиллагаа тогтвортой байх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн болох нь харагдаж байна.

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжсэн. Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар бүлэгт “Улс төрийн намын санхүүжилт”-тэй холбоотой зохицуулалтуудыг нарийвчлан хуульчилж өгсөн бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан “...намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нийтэд ил тод байх” зарчмыг бүрэн дүүрэн хангахтай холбоотой юм.

Нөгөө талаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан дээрх зарчмын шаардлага нь Улс төрийн намын зохион байгуулалт, үйл ажиллагаа тогтвортой байх эрх зүйн үндэслэл, нөхцөлийг хуулиар бий болгоход чиглэгдсэн буюу улс төрийн намын санхүүжилттэй холбоотой хуульд заасан зохицуулалт нь намын үйл ажиллагааг хязгаарлах, хумих үр дагаварт хүргэж болохгүй юм.

Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Нам энэ хуулийн 26.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авах бөгөөд өөр харилцах данстай байхыг хориглоно.”, гэж заасан нь Монгол Улсын Үндсэн

хуульд заасан намын хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нээлттэй ил тод байх шаардлагыг хангах нөхцөл, боломжийг хуульчилсан мэт боловч нам улсын хэмжээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагдах орлогыг хүлээн авах, зарцуулах ажиллагааг бүхий л түвшинд удирдан явуулах боломжгүй байдалд хүргэж байна.

Тодруулбал: Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, нам байгуулах, намд элсэх, намаас гарах, хууль тогтоомж болон тухайн намын дүрэм, намын хөтөлбөрт нийцүүлэн түүний үйл ажиллагаанд оролцох, намыг дэмжих, эс дэмжих эрхтэй.”, гэж заасан бөгөөд Улс төрийн нам нь төлөөллийн байгууллага бөгөөд аймаг, нийслэл, сум дүүргүүдэд салбар бүхий намын анхан, дунд, дээд шатны байгууллагаас бүрддэг онцлогтой.

Намын шат шатны байгууллага нь банкны харилцах дансгүй, зөвхөн төв байгууллагын дансаар орлого, зарлагаа нэгдсэн байдлаар явуулах бодит боломжгүй бөгөөд энэ нь Улс төрийн намын үйл ажиллагааг тогтвортой явуулах эрх зүйн үндэслэл, нөхцөлийг шууд хязгаарласан байна.

Мөн Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д “Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4-т заасан орлогын нийлбэрээс хоёр дахин их, эсхүл түүнээс илүү байж болохгүй.”, мөн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-т “Намын нэг жилд өөрийн хөрөнгө, түүнээс олсон орлого нь тухайн намд олгосон төрийн санхүүжилтийн 50 хувиас ихгүй байна”, гэж тус тус заасан нь Улс төрийн намын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Улсын Их Хурлын ээлжит, эсхүл ээлжит бус сонгуулиар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогч /цаашид "нийт сонгогч" гэх/-ийн тоог нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 0.7 хувиар үржүүлснээс илүүгүй төгрөгийг улсын төсвөөс намуудад энэ хуульд заасны дагуу хуваарилах замаар төрийн санхүүжилт олгоно.”, гэж заасантай шууд зөрчилдөж байхын зэрэгцээ Улс төрийн намын орлогын эх үүсвэрийг төрийн санхүүжилттэй холбох байдлаар хязгаарлалт тогтоож байгаа нь намын үйл ажиллагааг хумигдуулж, бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах, санхүүгийн хувьд нам дотооддоо бэхжих үйл явц эрх зүйн хувьд боломжгүй юм.

Цаашлаад Улс төрийн намын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14-т “Намын санхүүгийн тайланд намын салбар болон бүтцийн нэгж, намын дэргэдэх бодлогын судалгааны байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэж, харьяа байгууллагын санхүүгийн мэдээллийг тусгана.”, гэж заасан нь Улс төрийн намын дэргэдэх байгууллагын үйл ажиллагаа мөн хумигдах, үйл ажиллагааг улсын хэмжээнд явуулах эрх зүйн болон санхүүгийн боломжийг хязгаарлах, мөн түүнчлэн санхүүгийн тайланг нэгтгэн гаргаснаар хуульд заасан санхүүжилтийн дээд хэмжээ зөрчигдөхөд хүргэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаатай эдлэх талаар тодорхой зааж Улс төрийн намын үйл ажиллагаанд

оролцох, эс оролцох эрхийг хуульчилсан боловч намын үйл ажиллагааг санхүүгийн хувьд хязгаарлаж байгаа нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг шууд бусаар зөрчиж байгаа хэлбэр тул дээрх зохицуулалтуудыг өөрчлөх шаардлагатай байна.

## **1.2. Практик шаардлага**

Улс төрийн намын тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Улс төрийн нам банкны зөвхөн нэг данстай байхаар зохицуулснаас үүдэн намын шат шатны байгууллагын үйл ажиллагаа санхүүгийн төлбөр тооцоо, мөнгөн гүйлгээтэй холбоотойгоор зогсонги байдалд орох, хугацаа алдах зэргээр намын шат шатны байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүссэн. Энэ нь намын орлогын эх үүсвэр, зарцуулалт ил тод нээлттэй байх хуульд заасан шаардлага хангагдах боломжгүйд хүргэж, мөн иргэдийн улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох эрхийг бодитой эдлүүлэх эрх зүйн баталгаа хангагдахгүйд хүргэж байна.

Мөн Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намуудад санхүүжилт олгох, санхүүжилтийн хэмжээнээс хамаарч намын бусад орлогын хэмжээнд хязгаарлалт тогтоож байгаа нь намын үйл ажиллагаа тогтвортой явуулах, санхүүгийн хувьд дотооддоо бэхжих боломжийг хааж байгаа хэлбэр юм. Тухайлбал: Улс төрийн намын орон нутаг дахь салбар, хороодын тоо, үйл ажиллагааны цар хүрээ, намын өөрийн хөрөнгийн хэмжээ зэргээс хамаарч улс төрийн намууд харилцан адилгүй тул намд орж ирэх Төрийн санхүүжилтээс бусад аливаа орлогын хэмжээ нь цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байж болох юм.

Үүнийг төрөөс олгох санхүүжилтийн хэмжээтэй уялдуулан механик байдлаар хязгаарлалт тогтоох нь буруу юм. Мөн Улс төрийн намын дэргэдэх байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэж, харъяа байгууллагуудын санхүүгийн мэдээллийг тусгахаар хуульчилж өгсөн нь улс төрийн нам санхүүгийн тайлагналын хувьд олон дамжлага, хүндрэл үүсгэхийн зэрэгцээ хуульд заасан санхүүжилтийн дээд хэмжээ зөрчигдөхөд хүргэж байна.

### **Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 3 зүйлтэй. Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7-д “Нам нь энэ хуулийн 26.1.1-д заасан орлогыг зөвхөн нэг банкны дансаар хүлээн авч зарцуулна” гэж орлогын төрлийг/Төрийн санхүүжилт/ тусгайлан дурьдах байдлаар өөрчлөх, хуулийн 27.8-д “Улсын төсвөөс нэг намд олгох санхүүжилтийн нийт хэмжээ нь тухайн намын энэ хуулийн 36.3.1, 36.3.2, 36.3.3, 36.3.4-т заасан орлогын нийлбэрээс илүү байж болохгүй”.

Хуулийн 35.4-т заасныг бүхэлд нь хасах гэж өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулав.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлаас батлагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга бодитоор хэрэгжих боломжтой болохын зэрэгцээ Улс төрийн намын аймаг, нийслэл, сум, дүүргийн анхан шатны нэгж санхүүгийн хувьд нээлттэй, ил тод байх зарчмыг хангах, шат шатны намын байгууллагуудын үйл ажиллагаа тогтвортой хэвийн явагдах эрх зүйн үндэслэл бүрдэх юм.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төслийг дагаж бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ